



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 4/1111

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 3 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141211981

Эрүүл Мэндийн сайдын 2021 оны  
 07 дугаар сарын 07 ны өдрийн  
 07 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА ОЛГОХ  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХҮГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Роберт Жероме Мичуад Robert Jerome Michuad	Америкийн Нэгдсэн Улс	"Интернейшнл СОС Монголиа лимитед" ХХК-ний эмнэлэг	-	ГЭ00002545	Яаралтай тусламж судлал	Эмчлэх	6 сар
2.	Санжай Шарма Sanjay Sharma	Бүгд Найрамдах Барба Улс	Хатагтай ХХК эмнэлэг	-	ГЭ00002546	Нүвр ам судлал	Эмчлэх	6 сар


 Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
 07 дугаар сарын 07-ны өдрийн  
 07/07 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАДА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН  
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИЛГЭЛ,  
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний серви/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чилгэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хэн Сил Ги Нулунг Сил Ги	Бүгд Найрамдах Солонгос Улс	Ач Тус Хоспис ХХК- н Агаге эмнэлэг	-	ГЭ00002547	Мас засал судлал	Эмчлэх	1 жил
2.	Ким Бюн Ил Ким Вулунг II	Бүгд Найрамдах Солонгос Улс	Хүрэн Баавтай ХХК-н Нью Дентал эмнэлэг	-	ГЭ00002548	Нүүр ам судлал	Эмчлэх	1 жил
3.	Освальдо Гебреера Роше Oswaldo Gabriela Roche	Бүгд Найрамдах Куба Улс	Довлоо ХХК Юнайтед эмнэлэг	-	ГЭ00002549	Нүүр ам судлал	Эмчлэх	1 жил